



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2018 оны 07 сарын 02 өдөр

Дугаар А/249

Чингис хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсгийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хэрлэн сумын Засаг даргад эрхийг шилжүүлсэн Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хуулийн XII.1.44-д тусгагдсан "Хэнтий аймгийн Хэрлэн сумын Нийтийн эзэмшлийн талбайн тохижилт, ус зайлуулах шугамын ажил"-ын гүйцэтгэлийн явцтай танилцаж чанар байдалд дүгнэлт хийх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:	Ц.Чогсомжав	-Аймгийн Засаг даргын орлогч
Нарийн бичгийн дарга:	Д.Баттулга	-Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн Дэд бүтэц, төлөвлөлтийн бодлого хариуцсан мэргэжилтэн
Гишүүд:	Э.Мөнх-Эрдэнэ	- Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга
	Б.Гантөгс	-Газрын харилцаа барилга хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга
	Ц.Идэрбат	-Хэрлэн сумын Засаг дарга бөгөөд Чингис хотын Захирагч
	Г.Мөнхжаргал	-Хэрлэн сумын Засаг даргын Тамгын газрын Дэд бүтэц хариуцсан мэргэжилтэн

2. Тендер шалгаруулалт болон Улсын төсвийн хөрөнгийг үр дүнтэй зарцуулж буй эсэхтэй танилцах ажлыг шуурхай зохион байгуулж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч Засаг даргын орлогч /Ц.Чогсомжав/-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА

D:\My Documents\Захирамж 2018.doc